



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 23/01

Чойбалсан хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9,
“Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалт, Хувьцаа
эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ТОГТООХ НЬ:

Нэг. “Адуунчулуун” хувьцаат компанийн 2022 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг
баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ШАТАР



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 23/02

Чойбалсан хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны
үйл ажиллагааны тайланг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15,
“Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.8 дахь заалт, хувьцаа
эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ТОГТООХ НЬ:

Нэг. “Адуунчулуун” хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022
оны үйл ажиллагааны тайланг хангалттай гэж үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА *Б.Шатар* Б.ШАТАР





“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 23/03

Чойбалсан хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны цалин урамшуулал,
зардлын төсөв батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13,
“Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, хувьцаа
эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ТОГТООХ НЬ:

Нэг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны цалин урамшуулал,
зардлын төсвийг хавсралтаар баталсугай

Хоёр. Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн зардлын зарцуулалтад
хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын
хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ШАТАР

"Адуунчулуун" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны зардлын төсөв

д/д	Зардлын төрөл	Нийт зардал /төг/
Цалин, урамшууллын зардал		
1	ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин	92,544,000
2	НДШ /Байгууллагаас/	12,517,440
Бусад зардал		
1	Сэлбэг	1,613,872
2	Бинзен	11,452,352
3	Дизель түлш	332,995
4	Шатах тослох материал	472,172
5	Шуудан холбоо	1,280,779
6	Сургалт	525,727
7	Бичиг хэрэг	67,518
8	Бусдаар гүйцэтгүүлсэн	175,150
9	Бусад	2,001,014
Нийт дүн		123,030,019



"АДУУНЧУЛУУН" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 23/04

Чойбалсан хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, компанийн дүрмийн 7.8.1 дэх заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ТОГТООХ НЬ:

Нэг. Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг доорх бүрэлдэхүүнтэйгээр 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл нэг жилийн хугацаатайгаар тус тус сонгосугай. Үүнд:

а. Ердийн гишүүдээр:

- Санжаа овогтой Бадарч /1608367 кумулятив санал/
- Баттогтох овогтой Батсайхан /1608667 кумулятив санал/
- Шатар овогтой Баясгалан /1608917 кумулятив санал/
- Тогооч овогтой Даваасүрэн /1608367 кумулятив санал/
- Шатар овогтой Идэр /1608667 кумулятив санал/
- Баттогтох овогтой Шатар /1609017 кумулятив санал/

б. Хараат бус гишүүдээр:

- Юра овогтой Батбаатар /1608667 кумулятив санал/
- Баажаа овогтой Ганчулуун /1608967 кумулятив санал/
- Түвшинжаргал овогтой Даш-Эрдэнэ /1608367 кумулятив санал/

ХУРЛЫН ДАРГА



Б.ШАТАР

"Адуунчулуун" ХК, өөрийн байр, 8-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, Монгол улс
Утас/факс: 50021392, Имэйл: info@aduunchuluun.mn, Вэб: www.aduunchuluun.mn



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар...23/05

Чойбалсан хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 47 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12, “Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 10.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 сарын 16-ны өдрийн 23/01 тогтоол зэргийг тус тус үндэслэн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААС ТОГТООХ нь:

1. Адуунчулуун” ХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хэлэлцээд нэгж хувьцаанд 50 /тавь/ төгрөгийн ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг компанийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-иар зуучлуулан гүйцэтгүүлж, ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулж, төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал /Ш.Баясгалан/-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ШАТАР